

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2012-2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 5 дугаар  
сарын 20-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа**

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Я.Содбаатар, Л.Энх-Амгалан нар энэ асуудлыг Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлэг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах шаардлагатай байгаа тул хэлэлцүүлгийг хойшлуулах тухай горимын санал гаргасныг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүдийн олонх нь дэмжээгүй болно.

Дээрх асуудлыг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл 2008-2012 онд байсан дундаж орлоготой иргэдийн тоог энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрэгжсэн 2 жилийн тоотой харьцуулахад хэдэн хувиар нэмэгдсэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагаагаа явуулахад дарамт их байгаа тухай иргэдээс ирсэн гомдлыг хэрхэн шийдвэрлэх, өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэд зээлийн хүү 15-18 хувь, инфляци 12.5 хувь, үнийн өсөлт 30-40 хувьд хүрч, долларын ханш 1820 төгрөг болж эдийн засаг хүндэрсэн тул цалин тэтгэвэр, тэтгэмжийг нэмэх талаар ямар арга хэмжээ авах, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Үндэсний аудитын газар 2013 оны үндсэн чиглэлийн биелэлтэд хийсэн дүгнэлтдээ ажилгүйдэл, инфляци өсөж, макро түвшинд 1 хүнд ногдох ДНБ болон эдийн засгийн бүх үзүүлэлтүүд буурсан байдалтай байгаа энэ үед Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан төрийн үйлчилгээний болон захиргааны албан хаагчид цалингаараа хангалуун амьдрах, орон сууц худалдан авах болон алслагдсан хөдөө орон нутагт ажиллаж байгаа багш, ажилчдын цалин урамшуулал, орон сууцны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн тусгай хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн хангах, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн талаар асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Я.Содбаатар нар мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт 51 хувьтай байна гэсэн нь бодит амьдралтай нийцэхгүй байна. Иймд үндсэн чиглэлийн биелэлтийг дүгнэх аргачлал оновчтой, тодорхой байх, төлөвлөлт, хэлэлцэх дэгийг улам илүү боловсронгуй болгох шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей Үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг жил бүр хэлэлцдэг нь Засгийн газарт тавьж байгаа Улсын Их Хурлын хяналтын нэг хэлбэр тул Чуулганы хуралдааны дэгийн дагуу холбогдох Байнгын хороод хэлэлцээд, саналаа харьяалах Байнгын хороонд хүргүүлж байх нь зүйтэй гэсэн санал тус тус гаргасан болно.

Тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд Үндсэн чиглэл, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хангалтгүй хэрэгжсэн, удааширсан, хойшилсон зорилт, арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд тавих хяналтыг сайжруулж ажиллахыг Засгийн газарт үүрэг болгох нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.БАТЦОГТ

